



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2009 оны 2 сарын 13 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

Тогтоол хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын в, 29.2 дахь заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 13 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн хаалтын баланс болон бусад холбогдох шийдвэрийг гаргахыг Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн /Г.Болд/-д даалгасугай.

Хоёр. Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн татан буугдсантай холбогдуулан тус хүрээлэнгийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг Нийслэлийн барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын балансад зохих журмын дагуу 2009 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор шилжүүлэхийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Д.Однасан/-т үүрэг болгосугай.

Гурав. Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг зохих журмын дагуу хүлээн авч ажил үйлчилгээ, гэрээт ажлуудыг гэрээний дагуу 2009 оны 06 дугаар сард багтааж гүйцэтгүүлж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Барилга хот байгуулалт, төлөвлөлтийн газар /Н.Нацагдорж/-т даалгасугай.

Дөрөв. Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг хавсралтаар баталсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Г.МӨНХБАЯР



Нийслэлийн Засаг даргын 2009 оны
2 дугаар сарын 13-ны өдрийн
52 дугаар захирамжийн хавсралт

НИЙСЛЭЛИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ,
ЗУРАГ ТӨСЛИЙН ХҮРЭЭЛЭНГ ТАТАН БУУЛГАХ КОМИСС

Комиссын дарга	Б.Баатарзориг	Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч
Гишүүд	Н.Нацагдорж	Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын дарга
	Ч.Однасан	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга
	М.Цэрэндорж	Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын орлогч дарга
	Ч.Эрдэнэ-Очир	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга
	М.Батбаяр	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын хэлтсийн дарга
	Л.Ганбат	Нийслэлийн Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн хэлтсийн дарга
	Л.Бямбасүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Бямбасүрэн	Нийслэлийн Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Баяраа	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын архитектор
	Ц.Хорлоо	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын архитектор
	Ц.Ганцэцэг	Нийслэлийн Архивын газрын ахлах мэргэжилтэн
	Ж.Оюунчимэг	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын ерөнхий ня-бо
	Д.Энхжаргал	Нийтлэг үйлчилгээний газрын ерөнхий ня-бо
	Н.Бат-Өлзий	Нийслэлийн Барилга, хот байгуулалт, төлөвлөлтийн газрын нярав
	Н.Болормаа	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Ц.Оюунсайхан	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын мэргэжилтэн